

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ИЙН
2017 ОНЫ АУДИТЛАГДСАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АГУУЛГА**ХУУДАС**

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3 - 4
ОРЛОГЫН ТАЙЛАН	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9-18

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

АЛБАН ХАЯГ:

Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1-р
багийн II хэсэг – 0. Утас 99117636

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

1. Ч.Энхболд (ТУЗ-ын дарга)
2. Ч.Амарсанаа (Гүйцэтгэх захирал)
3. С.Отгонбаяр
4. Б.Лхагвадорж
5. Б.Пүрэвбаатар
6. А.Батболд
7. Б.Батбаатар
8. Х.Батхишиг
9. Б. Санжаа

ХАРИЛЦАГЧ БАНКУУД:

ХААН банк, Хас банк, Капитал банк,
Төрийн банк болон Худалдаа Хөгжлийн
банкинд Төгрөгийн, Хас болон Худалдаа
хөгжлийн банкинд ам.долларын
харилцах данстай.

АУДИТОР:

“Нийслэл - Аудит” ХХК

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК -ийн Захирал Ч.Амарсанаа болон нягтлан бодогч Э.Ариунтуяа бид энэхүү тайлангийн 5-18 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайлан, тодруулга нь 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бөгөөд бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



Э.АРИУНТУЯА



“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

2018 оны 02 сарын 02 өдөр

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид танай байгууллагын 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Зөрчилгүй дүгнэлт

Танай байгууллага 2017 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн “Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага” хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана.

Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм.

Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв. Аудит хийхдээ аудитын горим (Шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгах гэх мэт)-уудыг ашиглав.

Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

Тайлангийн зориулалт

Энэхүү тайланг танай байгууллагын хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиталсан санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.



Т.СУГАРСҮРЭН

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН ОРЛОГЫН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Тодруулга	2016	2017
			мян.төг	мян.төг
1	Тээвэр зуучийн орлого	3	553,480.6	345,066.9
2	Үзүүлсэн үйлчилгээний өртөг		-	-
3	Нийт ашиг		553,480.6	345,066.9
4	Түрээсийн орлого	4	32,318.3	37,500.0
5	Хүүний орлого		1,222.8	21.6
6	Бусад орлого		61,517.4	87,785.8
7	Удирдлагын зардал	5	911,424.4	822,042.4
8	Санхүүгийн зардал		32,130.9	26,909.6
10	Гадаад валютын ханшны зөрүүний гарз		592.1	(7.1)
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		-	-
12	Бусад зардал	6	(18,611.0)	(4,294.7)
13	Татвар төлөхийн өмнөх ашиг		(313,035.1)	(382,879.5)
14	Орлогын татварын зардал	7	1,184.3	2.2
15	Тайлант үеийн цэвэр ашиг		(314,219.4)	(382,881.7)
16	Нэгж энгийн хувьцаанд ногдох ашиг, төгрөгөөр	8	(6.80)	(8.30)

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН
БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тод - руулга	2016.12.31 мян.төг	2017.12.31 мян.төг
ХӨРӨНГӨ			
<u>Эргэлтийн Хөрөнгө</u>			
Мөнгөн хөрөнгө	9	4,597.7	2,925.1
Дансны авлага	10	1,265.0	634.5
Бусад авлага		0.5	
Хангамжийн материал	11	92,143.6	96,445.8
Эргэлтийн хөрөнгийн дүн		98,006.8	100,005.4
<u>Эргэлтийн бус хөрөнгө</u>			
Үндсэн хөрөнгө	12	6,041,497.4	4,798,599.5
Хуримтлагдсан элэгдэл		(1,060,569.9)	
Биет бус хөрөнгө	13	773,850.0	698,864.3
Хойшлогдсон татварын хөрөнгө		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		5,754,777.5	5,497,463.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		5,852,784.3	5,597,469.2
<u>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР</u>			
<u>Богино хугацаат өр төлбөр</u>			
Дансны өглөг	14	104,167.6	283,994.4
Татвар, шимтгэлийн өглөг		24,771.7	39,916.5
Банкны богино хугацаат зээл			
Урьдчилж орсон орлого			
Богино хугацаат өр төлбөрийн дүн		128,939.3	323,910.9
<u>Урт хугацаат өр төлбөр</u>			
Урт хугацаат зээл	15	149,459.0	82,054.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн		149,459.0	82,054.0
Өр төлбөрийн нийт дүн		278,398.3	405,964.9
<u>Эздийн өмч</u>			
Энгийн хувьцаа	16	4,620,000.0	4,620,000.0
Нэмж төлөгдсөн капитал		154,000.0	154,000.0
Хуримтлагдсан ашиг	17	25,528.0	(357,353.7)
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		774,858.0	774,858.0
Эздийн өмчийн дүн		5,574,386.0	5,191,504.3
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР		5,852,784.3	5,597,469.2

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа (мян.төг)	Нэмж төлөгдсөн капитал (мян.төг)	Хуримтлагдсан ашиг (мян.төг)	Эздийн өмчийн бусад хэсэг (мян.төг)	Нийт дүн (мян.төг)
2015.12.31 нээрх үлдэгдэл	4,620,000.0	154,000.0	339,747.4	774,858.0	5,888,605.4
Эзний нэмж оруулсан хөрөнгө					
Хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
Ногдол ашиг					
2016 оны татварын дараах алдагдал			(314,219.4)		(314,219.4)
2016.12.31 нээрх үлдэгдэл	4,620,000.0	154,000.0	25,528.0	774,858.0	5,574,386.0
Эзний нэмж оруулсан хөрөнгө					
Хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
Ногдол ашиг					
2017 оны татварын дараах алдагдал			(382,881.7)		(382,881.7)
2017.12.31 нээрх үлдэгдэл	4,620,000.0	154,000.0	(357,353.7)	774,858.0	5,191,504.3

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	731,570.1	517,634.8
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	725,137.5	516,625.5
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан	3,925.0	1,000.6
	Бусад мөнгөн орлого	2,507.6	8.7
1.2	Мөнгөн зарлага (-)	747,413.7	607,508.3
	Ажиллагчдад төлсөн	207,747.5	222,555.9
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	47,470.2	30,689.3
	Бараа материал худалдан авахад төлсөн	171,888.3	115,268.2
	Ашиглалтын зардалд төлсөн	67,813.2	67,085.7
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	74,509.6	54,251.6
	Хүүний төлбөрт төлсөн	32,130.9	26,909.7
	Татварын байгууллагад төлсөн	74,046.1	68,828.2
	Даатгалын төлбөрт төлсөн	742.7	538.5
	Бусад мөнгөн зарлага	71,065.2	21,381.2
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,843.6)	(89,873.5)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,584.6	402.6
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого	1,222.8	21.6
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	9,361.8	381.0
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(10,000.0)	(17,615.3)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,000.0	16,625.3
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	990.0
2.3	гүйлгээний дүн	584.6	(17,212.7)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	215,000.0	195,950.0
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(285,898.2)	(90,536.3)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	(70,898.2)	105,413.7
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(86,157.2)	(1,672.6)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	90,755.0	4,597.7
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,597.7	2,925.1

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“Э-Транс” ХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ачаа шилжүүлэн ачих терминалын төслийг хэрэгжүүлэх зорилгоор “Э-Транс ложистикс” ХХК-ийг 2011 онд байгуулсан. “Э-Транс ложистикс” ХХК нь 2012 оны 5-р сард хувьцаат компани болж Монголын хөрөнгийн биржэд бүртгүүлсэн. Нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 46,200,000 ширхэг энгийн хувьцаатай.

Компанийн удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирал нь тус компанийн гүйцэтгэх удирдлагын дээд албан тушаалтан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулдаг.

Компани нь БНХАУ-ын Эрээн боомтоор дамжин ачааны машинаар тээвэрлэгдэн ирж буй импортын барааг вагонд, вагоноор ирж буй экспортын барааг ачааны машинд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагааг явуулдаг. Мөн гаалийн хяналтын бүсээр зарлуулан гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

2.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

Компанийн санхүүгийн тайланг компанийн үйл ажиллагаа тасралтгүй явагдсаар байна гэсэн үндэслэлээр, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) – ын дагуу бэлтгэсэн бөгөөд түүхэн өртөгт суурилсан. Санхүүгийн тайлан дахь дүнг компанийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр, мянганы орноор нарийвчилсан болно.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(а) Орлогын бүртгэл

Компанийн үндсэн үйл ажиллагааны орлого нь ачаа тээврийн зуучлалын үйлчилгээний орлого юм. Өмнөх санхүүгийн тайлангуудад үйлчлүүлэгчдээс хүлээн авсан мөнгийг орлогоор, төмөр замд төлсөн тээврийн хөлсийг зардал (үзүүлсэн үйлчилгээний өртөг)-аар бүртгэж зөрүүгээр нь нийт ашгийг тодорхойлж байсан бол 2015 оны 10 сарын 1-ээс энэхүү төмөр замын тээврийн хөлсийг хассан цэвэр дүнг орлого гэж бүртгэх болсон. Нягтлан бодох бүртгэлийн энэхүү бодлогыг цаашид ч тууштай мөрдөх юм.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

(б) Гадаад валютаарх ажил гүйлгээний бүртгэл

Компани нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг.

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээний дүнг тухайн өдрийн спот ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар байгаа мөнгөн хөрөнгө ба гадаад валютаар төлөгдөх авлага, өглөгийг балансын өдрийн хаалтын ханшаар илэрхийлдэг. 2016 оны 12 сарын 31-ний өдрийн хаалтын ханш 1 ам.доллар = 2,489.53 төгрөг. Ханшийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ.

Түүхэн (өмнөх хугацааны) өртгөөр хэмжигдсэн гадаад валютаарх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар бүртгэж тайлагнадаг. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар тайлагнана.

(в) Үндсэн хөрөнгө

НББОУС 16 Үндсэн хөрөнгө-д заасны дагуу дараах шалгуурууд нэгэн зэрэг биелэгдсэн үед үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэлд тусгадаг.

- а) Аж ахуйн нэгжид ирээдүйн эдийн засгийн үр өгөөж авчрах боломжтой байх; ба
- б) Хөрөнгийн өртгийг үнэн зөв хэмжих боломжтой байх.

Үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэгт буй бүх зүйлсийг холбогдох элэгдэл болон үнэ цэнийн бууралтын гарзыг (хэрэв байгаа бол) хассан дүнгээр өртгөөр нь тайлагнадаг. Үндсэн хөрөнгийн урсгал засварын зардлуудыг гарсан даруйд нь тайлангийн үеийн зардлаар бүртгэж орлого үр дүнгийн тайланд тусгадаг.

Үндсэн хөрөнгийг шулуун шугамын арга ашиглан Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль-д заасан ашиглалтын хугацааг баримтлан элэгдүүлдэг. Үүнд:

Барилга, байгууламж	40 жил
Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер	3 жил

СЗХ-ноос шаардсаны дагуу хөрөнгийн үнэлгээний “Пантеон” ХХК-аар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Нийт 225 нэр төрлийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ 5,783,262.9 (таван тэрбум долоон зуун наян гурван сая хоёр зуун жаран хоёр мянга есөн зуун) мян. төгрөг болж, үлдэгдэл өртгөөсөө 186.762.2 мян.төгрөгөөр буурсан. Энэ хэмжээгээр эзэмшигчдийн өмчийн бусад хэсгийг бууруулсан.

(г) Биет бус хөрөнгө

НББОУС 38 Биет бус хөрөнгө стандарт, Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг баримтлан газар эзэмших эрх болон анхдагч зах зээлд хувьцаа гаргахтай холбоотой зардлыг биет бус хөрөнгөөр бүртгэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг баримтлан ашиглалтын хугацааг 10-15 жилээр тооцож хорогдуулга тооцож байна.

(д) Татвар

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.1.2.-д “Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад, гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсын нутгаар дамжуулан бусад улсад гаргасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ”-нд НӨАТ-ын “0” хувь хэмжээг хэрэглэхээр заасны дагуу үндсэн үйлчилгээнд НӨАТ төлдөггүй. Бусад хэлбэрээр олсон орлогод НӨАТ төлдөг.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)

Компани нь санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүнг Монгол улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль”-д заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулж татвар ногдох орлогыг тодорхойлон энэхүү дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Компани нь дээрх хуулийн дагуу 3 тэрбум төгрөг хүртэл ашгаас 10%, 3 тэрбум төгрөгөөс дээш ашгаас 25% -ийн орлогын албан татвар төлдөг.

Нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) ба Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)

Компани нь ажиллагчдын цалингаас Монгол улсын хууль тогтоомжийн дагуу НДШ ба ХХОАТ тооцдог. Ажиллагсдын олгохоор тооцсон цалин хөлснөөс НДШ- ийг хассан дүнгээс ХХОАТ суутган авч төсөвт шилжүүлдэг. Иргэдээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлснөөс НДШ ба ХХОАТ- ын хуулиудын дагуу зохих татвар шимтгэлийг суутган авдаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3. ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

Компанийн үндсэн орлого нь ачаа бараа шилжүүлэн ачилтын орлого юм. Шилжүүлэн ачилтын болон буултын орлогод НӨАТ ногдуулдаггүй. Ачаа хадгалалтын хөлс, оффисын түрээс, цайны газрын болон бусад орлогод НӨАТ ногдуулж төлдөг. Тайлант хугацааны үндсэн орлогыг нэр төрлөөр нь харуулав.

№	Орлогын төрөл	Дүн, мян.төг
1	Шилжүүлэн ачилтын орлого	160,252.0
2	Буултын орлого	10,320.0
3	Хадгалалтын орлого	20,397.9
4	Нэвтрэх үнэмлэхний орлого	118,828.2
5	Бусад орлого	35,268.8
	ДҮН	345,066.9

4. БУСАД ОРЛОГО

ХААН банк, Капитал банк, Төрийн банк зэрэг оффисийн өрөө түрээслэгчдийн түрээсийн төлбөр, цайны газрын орлого, банкнаас харилцах дансны үлдэгдэлд олгосон хүүний орлогыг бусад орлогод оруулсан.

№	Орлогын төрөл	Дүн, мян.төг
1	Түрээсийн орлого	37,500.0
2	Цайны газрын орлого	87,785.8
3	Хүүний орлого	21.6
	ДҮН	125,307.4

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

5. УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Хүснэгтэд 2017 оны үйл ажиллагааны зардлыг харуулав.

№	Зардлын нэр	ДҮН, мян.төг	
		2016	2017
1	Цалингийн зардал	221,331.3	142,644.1
2	Нийгмийн даатгалын шимтгэл	24,486.9	17,822.9
3	Сэлбэг, засвар үйлчилгээний зардал	26,158.3	10,164.4
4	Ашиглалтын (цахилгаан, дулаан, ус, холбоо, дохиолол, зам арчлалт)	61,510.4	67,183.4
5	Сургалтын зардал	2,496.6	1,290.0
6	Албан томилолтын зардал	36,475.0	103,824.0
7	Харуул хамгаалалтын зардал	43,457.3	3,640.5
8	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	278,304.5	282,227.9
9	Мэргэжлийн үйлчилгээний зардал	12,873.5	9,426.7
10	Шатахууны зардал	56,101.0	40,064.8
11	Бичиг хэргийн зардал	4,620.8	3,338.2
12	Аж ахуйн материалын зардал	12,886.7	14,446.3
13	Түрээсийн зардал	3,933.6	
14	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	32,117.6	41,253.4
15	Хөдөлмөр хамгааллын зардал		2,819.0
16	Бусад зардал	94,670.9	81,896.8
	БҮГД	911,424.4	822,042.4

6. БУСАД ЗАРДАЛ

№	Зардлын нэр	ДҮН, мян.төг
1	Баяр ёслолын зардал	1,737.4
2	Торгуулийн зардал	24.0
3	Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,533.3
4	Валютын ханшны зөрүүний гарз	7.1
	БҮГД	4,301.8

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

7. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын тайлангийн татварын өмнөх ашгийг НББОУС 12 Орлогын татвар стандартад заасны дагуу байнгын ба түр зөрүүгээр зохицуулж татвар ногдуулах орлогыг тодорхойлсон. Ийнхүү тодорхойлсон татвар ногдуулах орлогоос “Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар”-ын хуульд заасан шатлалийн дагуу 10 хувиар орлогын албан татварын зардлыг тооцсон.

№	Үзүүлэлтүүд	ДҮН, мян.төгрөг
1	Татварын өмнөх ашиг	(382,881.6)
2	<u>Байнгын зөрүү</u>	
	Нэмэх нь: ААНОАТ-ын хуулийн дагуу хасагдахгүй зардал	4,294.7
	Хасах нь: Хүүний орлого	21.6
3	<u>Түр зөрүү</u>	
	Нэмэх нь Санхүүгийн ба татварын тайлангийн элэгдлийн зардлын зөрүү	-
	Валютын ханшны бодит бус зөрүү	7.1
	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого	
	Шилжүүлсэн алдагдал	
4	Ногдуулсан татвар	-
5	Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого	21.6
6	Ногдуулсан татвар	2.2
7	Орлогын татварын зардал	2.2

8. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

2017 оны татварын дараах цэвэр алдагдал 382,881.6 мян.төг. Тайлант жилийн цэвэр алдагдлыг энгийн хувьцааны тоонд хувааж нэгж хувьцаанд ногдох алдагдлыг тооцсон.

№	Үзүүлэлтүүд	ДҮН, мян.төг
1	2017 оны цэвэр алдагдал	(382,881.6)
2	Энгийн хувьцааны тоо (ширхэг)	46,200,000
3	Нэгж хувьцаанд ногдох алдагдал (төгрөгөөр)	(8.29)

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

9. МӨНГӨН ХӨРӨНГӨ

	Банкны нэр	Дансны дугаар	2016.12.31		2017.12.31	
			ам.долл.	МНТ, мян.төг	ам.долл.	МНТ, мян.төг
MNT	Касс			1,115.7		1,183.3
MNT	Худалдаа хөгжлийн банк	454038630		549.7		331.8
	ХАС банк	5406216		98.6		98.6
	Төрийн банк	280500295704		509.4		12.5
	ХААН банк	5374446033		117.4		-
	Капитал банк			1,922.8		1,033.9
USD	Худалдаа хөгжлийн банк	454038924	114.11	284.1		265.0
	ХАС банк	5406224	-	-	-	-
ДҮН			114.11	4,597.70	-	2,925.1

10. ДАНСНЫ АВЛАГА

№	Харилцагчийн нэр	Тайлбар	ДҮН, мян.төг
1	Иргэн Мөнхтуул	тээврийн хөлсний дутуу	634.0
4	Нийгмийн даатгалын газар	тооцооны үлдэгдэл	0.5
	БҮГД		634.5

11. БАРАА МАТЕРИАЛ

Э-транс ложистик ХХК-д 96,445.8 мян.төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа ба үүнд ашиглалтад байгаа багаж хэрэгсэл, түргэн элэгдэх зүйлс, хөдөлмөр хамгааллын хувцас зэрэг байна.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

12. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тавилга, эд хотшил	Тоног төхөөрөмж	ДҮН, мян.төг
АНХНЫ ӨРТӨГ						
2016.12.31-ний үлдэгдэл	5,292,115.8	313,682.7	47,985.6	49,391.9	338,321.4	6,041,497.4
Дахин үнэлгээ						-
Тайланг хугацаанд нэмэгдсэн			5,939.0	5,676.8	12,198.4	23,814.2
Тайланг хугацаанд хорогдсон						-
2017.12.31-ний үлдэгдэл	5,292,115.8	313,682.7	53,924.6	55,068.7	350,519.8	6,065,311.6
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ						
2016.12.31-ний үлдэгдэл	657,333.8	155,220.9	44,352.8	22,478.5	181,183.9	1,060,569.9
Дахин үнэлгээ						-
Тайланг хугацаанд нэмэгдсэн	123,947.2	33,720.9	7,739.8	6,784.2	33,950.1	206,142.2
Тайланг хугацаанд хорогдсон						-
2017.12.31-ний үлдэгдэл	781,281.0	188,941.8	52,092.6	29,262.7	215,134.0	1,266,712.1
ЦЭВЭР ДҮН, 2017.12.31						
	4,510,834.8	124,740.9	1,832.0	25,806.0	135,385.8	4,798,599.5

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

13. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргахтай холбоотой 2012 онд “Би Ди Сек” ХК-ийн үйлчилгээний хөлсөнд төлсөн 171,714.1 мянган төгрөгийг биет бус хөрөнгөөр бүртгэж 10 жилийн хугацаатай элэгдүүлж байгаа.

№	Хөрөнгийн нэр	Анхны өртөг, мян.төг	Аш/хуг, жилээр	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн	2017 оны хорогдол	Нийт хорогдуулг ын зардал	Үлдэгдэл өртөг, мян.төг
1	Газар эзэмших эрх	865,384.5	15	173,076.9	57,692.3	230,769.2	634,615.3
2	Зохион байгуулалтын зардал	171,714.1	10	93,652.3	17,171.4	110,823.7	60,890.4
3	Датакомын эрх	153.7	10	44.8	15.4	60.2	93.5
4	Пүүний программ	3,400.0	10	28.3	1,133.4	1,161.7	2,238.3
5	Санхүүгийн программ	770.0	10			-	
6	Веб сайт	1,100.0	10		73.3	73.3	1,026.7
	БҮГД	1,042,522.3		266,802.3	76,085.8	342,888.1	698,864.2

14. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

№	Харилцагчийн нэр	Тайлбар	ДҮН, мян.төг
1	Чулуун-Эрдэнэс ХХК	КАТ универсал тракторын түрээс	18,764.2
2	Ч.Амарсанаа	зээл	174,500.0
3	Баянцемент ХХК	зээл	3,288.7
4	Э-транс ХХК	зээл	61,441.6
5	Нийслэл - Аудит ХХК	аудитын хөлс	6,000.0
6	Х.Батхишиг	зээл	20,000.0
7	Замын-Үүд татварын хэлтэс	ХХОАТ-ын өр	988.3
8	Замын-Үүд татварын хэлтэс	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	35,330.3
9	Замын-Үүд татварын хэлтэс	НӨАТ-ын өр	3,595.8
10	Бусад		2.0
	БҮГД		323,910.9

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

15. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

№	Зээлдүүлэгчийн нэр	Тайлбар	ДҮН, мян.төг
1	Худалдаа хөгжлийн банк	зээл	82,054.0
	БҮГД		82,054.0

16. ЭНГИЙН ХУВЬЦАА

Компани нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 46,200,000 ширхэг энгийн хувьцаатай. Үүнээс 38,500,000 ширхэг хувьцаа нэрлэсэн үнээрээ буюу 100 төгрөгөөр, 7,700,000 ширхэг хувьцаа 120 төгрөгөөр борлогдсон.

№	Хувьцааны тоо	Худалдсан үнэ	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал
1	38,500,000	100.0	3,850,000,000.0	-
2	7,700,000	120.0	770,000,000.0	154,000.00
	46,200,000		4,620,000,000.0	154,000.0

17. ХУРИМТЛАГДСАН АШИГ

№	Үзүүлэлтүүд	ДҮН, мян.төг
1	Хуримтлагдсан ашгийн үлдэгдэл, 2016.12.31	25,528.0
2	Тайланг оны цэвэр алдагдал	(382,881.7)
3	Хуримтлагдсан ашгийн эцсийн үлдэгдэл, 2016.12.31	(357,353.7)